



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар A/84

Арвайхээр

Ажлын цагийг тусгай горимд шилжүүлэх
тухай

Улсын онцгой комиссын "Иргэд, зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай" 2020 оны 06 дугаар тогтоолын 3 дахь заалт, Онцгой байдлын өрөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам"-ын 2.4, 3.1.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ короновирус (COVID-19)-ын халдварт Монгол Улсад бүртгэгдсэнтэй холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, биеийн эрүүл мэнд, дархлааг дэмжих зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагч, ажилтнуудын ажлын цагийг 09.00-12.00, 14.00-17.00 цаг байхаар тогтоож 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл ажлын цагийн тусгай горимд шилжүүлсүгэй.
2. Ажлын цагийг богиносгож байгаатай холбогдуулан албан хаагч, ажилтнуудын ажилласан цагийн зөрүүг ажилласнаар тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.
3. Дээрх ажлын цагийн тусгай горимыг хорио цээрийн дэглэм цуцлах хүртэл мөрдөж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагч, ажилтнуудад үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ГАНБОЛД



012100205

D: My Doc. Tushaal. ZDTG